

**“ТОХИЖИЛТ НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ” ЗОРИЛТОД ЖИЛИЙН
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Арвайхээр хот

2019.12.10

д/д	Бодлогын зорилтууд, хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
Нэг. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр		
1.	Зорилтот жилийн нээлтийг зохион байгуулах	Аймгийн зорилтот жилийг зохион байгуулах ажлын хэсэгтэй хамтран 2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр ХДТеатрт зохион байгуулсан бөгөөд тус нээлтийн үеэр мод бутны тарьц суулгацын жилийн ажлын хуваарь, байгаль орчинд ээлтэй технологийн талаар иргэдэд мэдээлэл өгсөн бөгөөд 13 багийн 985 орчим иргэн хамрагдсан. <p align="right">Үр дүнтэй 100 хувь</p>
2.	Байгууллага аж ахуйн нэгжүүдтэй тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, сайжруулах гэрээ байгуулах	Гадна талбайдаа тохижилт хийх болох боломжтой нийт 76 төрийн болон төрийн бус байгууллага, 13 шатахуун түгээх станц, 13 багийн засаг даргатай тохижилт ногоон байгууламжийн талаар хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд гэрээний биелэлтийг 11 дүгээр сарын 15-ны дотор дүгнэж, шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байгууллага, аж ахуй нэгжүүдийг болзолт уралдаанд бүрэн хамруулсан. <p align="right">Үр дүнтэй 100 хувь</p>
3.	Шилдэг тохижилт, ногоон байгууламжтай баг, байгууллага, аж ахуйн нэгж, гудамж, айл өрх шалгаруулах болзолт уралдаан зарлах	8.000.0 төгрөгийн шагналын сан бүхий тус болзолт уралдаанд нийт 13 багийн 22 иргэн, 26 байгууллага, материалаа ирүүлсэн байна. Сонгон шалгаруулалтыг томилогдсон ажлын хэсэг зохион байгуулсан бөгөөд шалгарсан зарим иргэдийн материалыг аймгийн болзолт уралдаанд уламжилсан. <p align="right">Үр дүнтэй 100 хувь</p>
4.	Мод, сөөг, цэцгийн тарьц суулгац, үр бордооны үзэсгэлэн худалдааг зохион байгуулах.	2019 оны 05 дугаар сарын 04-06ны өдрүүдэд Аюуш баатрын талбайд зохион байгууллаа. Тус үзэсгэлэн худалдаагаар мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 8 аж ахуй нэгж, 3 иргэн оролцож 20 гаруй нэр төрлийн 9800 ширхэг суулгацыг иргэдэд борлуулсан бөгөөд гоёл чимэглэлийн болон жимсний мод бутыг иргэд түлхүү худалдан авсан байна. <p align="right">Үр дүнтэй 100 хувь</p>
5.	Сайн туршлага судалж хэрэгжүүлэх	Сумын ИТХурлын ажлын албатай хамтран Өмнөговь аймгийн Даланзадгад хотын тохижилт бүтээн байгуулалтын ажилтай танилцаж, сайн туршлага солилцох ажлыг 2019 оны 04 дүгээр сарын 11-13ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус аймгийн тохижилт ногоон байгууламжийн ажлын сайн

		туршлагыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үр дүнтэй 100 хувь
Хоёр. Тохижилтын ажлын чиглэлээр		
1.	Д.Пүрэвдоржийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнг тохижуулах	Тус цэцэрлэгт хүрээлэнд жил бүр мод бут тарих ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд 2017 онд Арвайн хүрээ утга зохиолын нэгдлийн яруу найрагчид 200 ширхэг гоёл чимэглэлийн бургас, 2018 онд ЕБСургуулийн бага ангийн сурагчид 250 ширхэг гоёл чимэглэлийн мод бут, 2019 онд Онги ус суваг ОНӨААТҮГазрын албан хаагчид 75 ширхэг чимэглэлийн нарс мод тарих ажлыг зохион байгуулсан. Хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу явган зам, гэрэлтүүлэг хийх тохижилтын ажлын зураг хийгдсэн боловч Мэргэд сургуулийн өргөтгөлийн ажил хийгдсэнтэй холбоотойгоор түр хойшлогдож, 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулсан. Үр дүнтэй 100 хувь
2.	Аюуш баатрын хөшөөний орчинг тохижуулах	Орон нутгийн төсвийн 50 сая төгрөгийн санхүүжилтээр Баян найман ХХК хийж гүйцэтгэж хүлээлгэн өгсөн. Үр дүнтэй 100 хувь
3.	Хуучин авто замуудын явган хүний замын засвар шинэчлэлтийг хийх	Шинээр 12.5 км авто зам тавигдсантай холбоотойгоор замын компаниудын ачаалал болон хөрөнгө санхүүгийн асуудал шийдэгдээгүй улмаас хийгдэх хугацаа хойшлосон. 2020 оны авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан. Үнэлэх боломжгүй
4.	“Арвайхээр соёл амралтын хүрээлэн”, Хүүхдийн паркийн орчны гэрэлтүүлгийг шинэчлэх, сайжруулах	Тендер шалгаруулалтад Арвайхээр цэцэрлэгжилт-ОНӨААТҮГазар шалгарсан бөгөөд нийт 29 сая төгрөгийн санхүүжилтээр орчны гэрэлтүүлэг нэмэгдсэн. Үр дүнтэй 100 хувь
5.	Буга согоот өндөрлөгийн засвар шинэчлэлтийг хийж гэрэлтүүлэг, сандал, камерыг сайжруулах	Нийтийн эзэмшлийн зам талбайд сандал, хогийн сав нэмэгдүүлэх тендерийн худалдан авалт хийгдэж байгаа бөгөөд тухайн объектод тус тендерийн багцаас зарим тохижилтыг хийнэ. Тодорхой үр дүнд хүрсэн 70 хувь
6.	Аймгийн хүндэтгэлийн хаалганы засвар, шинэчлэлт гэрэлтүүлэг хийх	Орон нутгийн төсвийн 2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гэрэлтүүлгийн зай хураагуур, лед гэрлийг шинэчлэх ажлыг Бумбат ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Үр дүнтэй 100 хувь
7.	Албан байгууллага аж ахуйн нэгжүүдийг хог ангилан ялгах савтай болгох	Сумын орон нутгийн хөгжлийн сангийн 9.8 сая төгрөгийн санхүүжилтээр иргэн Б.Наранбаатар 5 ш ангилан ялгах хогийн сав хийж нийтийн эзэмшлийн зам талбай болон орон сууцны гадна талбайд байрлуулсан бөгөөд тухайн хогийн

		савтай дүйцэхүйц савыг гадна талбайдаа байрлуулах талаар байгууллага аж ахуй нэгжүүдтэй хийсэн тохижилтын гэрээнд тусгагдсан бөгөөд гүйцэтгэлийн явцад хяналт тавин ажиллаж байна. Үр дүнтэй 100 хувь
8.	Орчин үеийн чанар стандартад нийцсэн автобусны буудлуудыг шинээр байгуулах	Сумын орон нутгийн хөгжлийн сангийн 66 сая төгрөгийн санхүүжилтээр 3,4,5,6,8,9,10,11,12,13 дугаар багуудад орчин үеийн стандартад нийцэхүйц лед гэрэл, камержуулалт бүхий нийтийн тээврийн 22 зогсоолыг Арвайхээр тохижилт үйлчилгээ-ОНӨААТҮГазар хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Үр дүнтэй 100 хувь
9.	Улсын бүртгэлийн хэлтсээс Ундрах эрдэм хэвлэлийн үйлдвэр хүртэлх авто замын засвар шинэчлэлт, явган хүний зам шинээр тавих	Шинээр 12.5 км авто зам тавигдсантай холбоотойгоор замын компаниудын ачаалал болон хөрөнгө санхүүгийн асуудал шийдэгдээгүй улмаас хийгдэх хугацаа хойшлогдсон. 2020 оны авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан. Үнэлэх боломжгүй
10.	Замын тэмдэг тэмдэглэгээг шинэчлэх, шаардлагатай газруудад шинээр хийх	Авто замын сангийн 73.8 сая төгрөгийн санхүүжилт тавигдсан бөгөөд тендерийн бичиг баримт боловсруулагдаж байна. Үнэлэх боломжгүй.
11.	Нийтийн эзэмшлийн зам талбайн сандал, хогийн савны тоог нэмэгдүүлэх	Орон нутгийн төсвийн 45 сая төгрөгийн санхүүжилтээр худалдан авах ажиллагаа зарлагдсан бөгөөд Баян найман ХХК шалгарч оны сүүлээр нийлүүлэлт хийгдэнэ. Үр дүнтэй 100 хувь
12.	Гэр хорооллын айл өрхийн цамхагт гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх	Орон нутгийн төсвийн 320 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 13 багийн нутаг дэвсгэрт 120 ширхэг цамхагт гэрэлтүүлэг байршуулах ажлыг Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Үр дүнтэй 100 хувь
13.	Зам цэвэрлэгээний автомашин худалдан авах	Орон нутгийн төсвийн 97 сая төгрөгийн санхүүжилтээр зам цэвэрлэх, угаах үйлдэл бүхий бүрэн автомат авто машиныг Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГазар нийлүүлсэн. Үр дүнтэй 100 хувь
14.	Нийтийн бие засах газар барих	2019 оны аймгийн төсөвт батлагдсан 150.0 сая төгрөгийн санхүүжилтийг хагас жилийн төсвийн тодотголоор өөр ажил үйлчилгээнд шилжүүлсэн. Үнэлэх боломжгүй
15.	Гэрэлт гудамж шинээр байгуулах, тохижуулах	Орон нутгийн төсвийн 200 сая төгрөгийн санхүүжилтээр гэрэлт гудамж байгуулах ажлыг Арвайхээр тохижилт үйлчилгээ-ОНӨААТҮГ хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Үр дүнтэй 100 хувь

16.	Талбайн соёмбот хөшөөг шинэчлэх, засварлах	Үнэлэх боломжгүй.
17.	Авто зогсоолын тоог нэмэгдүүлэх	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтыг сайжруулах ажлын хүрээнд улсын төсвийн 900 сая төгрөгөөр 16 байршилд 20000 м ² авто зогсоол бүрэн хийгдэж дууссан. Үр дүнтэй 100 хувь
18.	Хүүхэд залуучуудын паркад тавигдсан шинэ тоглоом руу явган зам, гүүр тавих	Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГазар өөрсдийн нөөц боломжид тулгуурлан хийж гүйцэтгэсэн. Үр дүнтэй 100 хувь
19.	Хүүхдийн эмнэлэг шинээр барих	Эрүүл мэндийн яамны 5 тэрбум 19 сая төгрөгийн санхүүжилтээр 50 ортой хүүхдийн эмнэлэгийн барилга угсралтын ажил 90 хувьтай байна. Үр дүнтэй 100 хувь
20.	Мэргэд сургуулийн өргөтгөл	БСШУЯамны 3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Мэргэд сургуулийн өргөтгөлийн барилгын ажлыг “Бага хөгшин” ХХК хийж гүйцэтгэн 12 сард хүлээлгэн өгсөн. Үр дүнтэй 100 хувь
21.	2-р цэцэрлэгийн өргөтгөл	БСШУЯамны 180 сая төгрөгийн санхүүжилтээр 2-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлыг Эрхэст ХХК хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Үр дүнтэй 100 хувь
22.	4-р цэцэрлэгийн өргөтгөл	БСШУЯамны 170 сая төгрөгийн санхүүжилтээр 4-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлыг Харшийн гэгээ ХХК хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Үр дүнтэй 100 хувь
23.	Нийтийн тээврийн парк шинэчлэл	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 340 сая төгрөгийн санхүүжилтээр 4 автобус нийлүүлэх ажлыг Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГазар хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Үр дүнтэй 100 хувь
24.	Авто замын шинэчлэл	Энэ онд авто замын сангийн 10 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтээр гэр хороололын багуудыг 12.5 км авто замыг шинээр хийж гүйцэтгэсэн. Үр дүнтэй 100 хувь
Гурав. Ногоон байгууламжийн ажлын чиглэлээр		
1.	Айл бүр–Арван мод аян өрнүүлэх	Тус аяны хүрээнд 13 багийн 385 өрх 4210 ширхэг навчит болон чимэглэлийн жимсний мод бут шинээр тарьсан байна. Үр дүнтэй 100 хувь
2.	Гоёл чимэглэлийн мод бут тарих	Энэ онд Хунбобса цэцэрлэгт хүрээлэн, Т.Намнансүрэнгийн нэрэмжит гудамж, Д.Пүрэвдоржийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн, БОАЖЯамны санхүүжилтээр хийгдсэн Ногоон төгөл цэцэрлэгт хүрээлэнд далан хальс, гүйлс, голт бор, нарс

		монос зэрэг нэр төрлийн 2247 орчим мод бут таригдсан бөгөөд амьдралт 81 хувь байна. Үр дүнтэй 100 хувь
3.	Нийтийн эзэмшлийн зам талбайн зүлэгжүүлэлт	Арвайхээр хотын нийтийн эзэмшлийн зам талбайн 25 байршил, Төв цэнгэлдэх хүрээлэн, Дэлгэрэх голын гулдралын дагуу 28500 м ² талбайд шинэ технологийн зүлэгжүүлэлтийн ажил хийгдэж дууссан бөгөөд усалгаа арчилгааг Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГазар хариуцан гүйцэтгэж байна. Үр дүнтэй 100 хувь
4.	Нийтийн эзэмшлийн талбайд цэцгийн мандал хийх	Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГазар нь энэ онд Петуня, Астра, Хилэнжин зэрэг нэр төрлийн 40000 орчим цэцгийн үрсэлгээ бэлтгэсэн бөгөөд нийтийн эзэмшлийн зам талбайн 12 цэцгийн мандалд 35000 ширхэг үрсэлгээ тарьж орчны өнгө үзэмжийг нэмэгдүүлсэн байна. Үр дүнтэй 100 хувь
5.	Т.Намнансүрэнгийн гудамжинд ургамлан хашлага тарих	Тус гудамжинд 12360 ширхэг хайлаас, 150 ширхэг гоёл чимэглэлийн мод бут тариалсан бөгөөд амьдралт 91 хувь байна Үр дүнтэй 100 хувь
6.	Т.Ренчинпэлжээгийн гудамжинд улиас тарих	Тус гудамжинд 177 ширхэг навчит мод болох улиасыг Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГазар хариуцан тариалсан бөгөөд амьдралт 92 хувь байна. Үр дүнтэй 100 хувь
7.	Хүнс барааны төв захаас Гандан пунцоглин хийд руу өгсөх авто замын дагуу мод тарих	Тус гудамжинд 294 ширхэг навчит мод болох улиасыг Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГазар хариуцан тариалсан бөгөөд амьдралт 95 хувь байна Үр дүнтэй 100 хувь
8.	Улсын чанартай АО301 дүгээр авто зам дагуу мод хэсэгчилэн тарих	Тус гудамжинд 188 ширхэг навчит мод болох улиасыг Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГазар, Арвайхээр тохижилт үйлчилгээ-ОНӨААТҮГазар хамтран тариалсан бөгөөд амьдралт 98 хувь байна. Үр дүнтэй 100 хувь
9.	Барилгачдын гудамж 4 дүгээр сургуулийн зүүн талд үечлэн хайлаас битүү тарих	Тус гудамжид БОАЖЯамны санхүүжилтээр Ногоон төгөл аяны хүрээнд 13 нэр төрлийн гоёл чимэглэлийн мод 2400 ширхэг мод бутыг шинээр тариалсан бөгөөд мод бутны нүх ухах ажлыг төрийн албан хаагчид болон ЕБСургуулийн ахлах ангийн сурагчид хийж гүйцэтгэсэн бөгөөд мод бутны амьдралт 95 хувь байна. Үр дүнтэй 100 хувь
10.	Хүүхэд залуучуудын паркад шинээр суурилуулсан тоглоомын дагуу болон урд хэсгээр мод тарих	Шинээр ашиглалтад оруулсан тоглоомын орчим гоёл чимэглэлийн нарс 50 ширхэг тарьсан бөгөөд усалгаа арчилгааг Арвайхээр цэцэрлэгжилт-ОНӨААТҮГазар хариуцан зохион байгуулж, амьдралт 91 хувь байна. Үр дүнтэй 100 хувь

11.	Ойгоос мод шилжүүлэн суулгах журмын дагуу модыг төв суурин газарт шилжүүлэн суулгах ажлыг зохион байгуулах	Намрын мод тарих өдрийг тохиолдуулан тус журмын дагуу Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумаас 350 ширхэг шинэсийг Дэлгэрэх голын голдролын дагуу шилжүүлэн суулгасан. Үр дүнтэй 100 хувь
Дөрөв. Хэвлэл мэдээлэл сургалт сурталчилгааны чиглэлээр		
1.	Арвайхээр хотын видео танилцуулга хийх	Зорилтот жилийн хүрээнд Хас телевизтэй байгуулсан гэрээний хүрээнд хотын ерөнхий танилцуулга болон тохижилт бүтээн байгуулалтын ажлын талаар 7-9 минутын видео танилцуулга хийгдэж байна. Үр дүнтэй 100 хувь
2.	Байгууллага аж ахуй нэгж, иргэдэд тохижилт, ногоон байгууламжийн чиглэлээр сургалт, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, сургалт зохион байгуулах	“Тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх” зорилтот жилийн хүрээнд гэр хорооллын айл өрхийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, тэднийг зөвлөгөө мэдээллээр хангах зорилгоор ногоон байгууламжийн нэгдсэн сургалтыг 2019 оны 4 дүгээр сарын 17-19ны өдрүүдэд аймгийн БОАЖГазартай хамтран 13 багийн нийт 256 иргэнийг хамруулан зохион байгууллаа. Тус сургалтаар мод бут, зүлэг, цэцэг тарих технологи, зорилтот жилийн ажлын төлөвлөгөө, аймгийн ИТХурлаар батлагдсан “Гэр хорооллын стандарт”-ын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн бөгөөд улиас, хайлаас, чацаргана зэрэг мод бутыг 0.5 га өрхийн хашаанд хэрхэн тарих талаар зарим иргэдийн хашаанд очиж, дадлага сургалтыг хийж гүйцэтгэсэн болно. Үр дүнтэй 100 хувь
3.	Арвайхээр тохижилт үйлчилгээ, Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГазар, Найрамдал, Онги өргөө СӨХ-ийн албан хаагчдад зорилтот жилийн ажлын талаар сургалт мэдээлэл хийж, өдөрлөг зохион байгуулах	Арвайхээр тохижилт үйлчилгээ, Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГазрууд болон Найрамдал, Онги-Өргөө СӨХолбоодын ажилчин албан хаагчдад зориулсан өглөөний цайны уулзалтыг энэ оны 11 сарын 07-ны өдөр зохион байгуулсан бөгөөд тус уулзалтад сумын удирдлагууд болон Ганданпунцоглин хийдийн хамба лам Я.Ганзаяа нар оролцож лекц ярилцлага хийн тэдний санал бодлыг сонсож, зорилтот жилийн ажлын үр дүнг танилцууллаа. Үр дүнтэй 100 хувь
4.	Тохижилт ногоон байгууламжийн чиглэлээр TV цуврал хичээл бэлтгэн иргэдэд хүргэх	Аймгийн зорилтот жилийн ажлын хэсэгтэй хамтран Навчит болон гоёл чимэглэлийн мод бут тарих арга зүй, Зүлэгжүүлэлтийн ажлын арга зүй, Мандлын цэцэг тариалах арга зүй зэрэг сэдвүүдээр цуврал цахим нэвтрүүлэг хийж бэлтгэсэн бөгөөд хэвлэл мэдээллийн байгууллага болон интернет орчинд иргэдэд сурталчлан ажиллаж байна. Үр дүнтэй 100 хувь
5.	Ногоон байгууламжийн сангийн журам болон бусад бодлогын баримт бичгүүдийг сурталчилсан богино	Зорилтот жилийн хүрээнд Хас, Соёмбо телевизтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд Айл бүр-Арван мод аян болон зорилтот жилийн бусад

	хэмжээний шторк хийх	ажлуудын талаар богино хэмжээний шторк хийж хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажиллаж байна. Үр дүнтэй 100 хувь
6.	Зорилтот жилийн хүрээнд хийгдэж байгаа ажлыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухай бүр мэдээлэх.	Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг гэрээт телевизүүдээр болон цахим хуудсуудаар дамжуулан цахим хичээл 5, шторк 3, цаг үеийн мэдээ 50, шилдэг тохижилттой айл өрх, байгууллагын сайн туршлагыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилтот нэвтрүүлэг 9, тохижилтын хүрээнд хийгдсэн ажлаар 2 нэвтрүүлгийг бэлтгэн хүргэсэн. Мөн Арвайхээрийн мэдээ, Арвайхээр хот page хаягуудад зорилтот жилийн ажлын талаарх мэдээллийг тогтмол сурталчлан ажиллаж байна. Үр дүнтэй 100 хувь

Тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтыг дүнгээр тооцоход 39 үйл ажиллагаа -Үр дүнтэй 100 хувьтай, 1 үйл ажиллагаа -тодорхой үр дүнд хүрсэн 70 хувьтай, 4 үйл ажиллагаа -үнэлэх боломжгүй биелэлт дүнгээрээ 99.2 хувьтай байна.

ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЛБА